



[www.sankhuuginbolovsrol.mn](http://www.sankhuuginbolovsrol.mn)

**ТӨВ БАНК**

# 1. БАНКНЫ САЛБАРЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

- ✓ Банк гэдэг нэр томъёо нь ‘banco’ /итали мөнгө солих ширээ/ гэдэг үгнээс гаралтай гэж үздэг бөгөөд энэ нь дундад зууны үед италичууд өөрийн мөнгийг солилцдог байсан газрыг хэлдэг байжээ.
- ✓ ХҮШ-ХІХ зуунд анхны улсын буюу үндэсний банкууд бий болж эхэлжээ.
- ✓ Төв банк яагаад үүссэн гэхээр тухайн үеийн цэргийн зардлаас үүдэлтэй санхүүгийн хямралыг даван туулах гэж үүссэн байна.
- ✓ 1990 онд “Аж ахуйн банк байгуулах болон түүний үйл ажиллагааны нийтлэг дүрэм”, 1991 онд “Банкы тухай хууль” батлагдсанаар Монгол Улсад 2 шатлалт банкны тогтолцооны хөрс суурь тавигджээ.



Венецэд анхны банк XII-XIII зуун



1668 он. Шведийн төв банк



1694 он. Английн төв банк



1924 он. Монголын худалдаа, аж үйлдвэрийн банк

## 2. МОНГОЛЫН ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ

- 1924 оны 06 сарын 02-нд Монгол, Зөвлөлт Орос улсын хувь нийлүүлсэн хөрөнгөөр Монголын худалдаа, аж үйлдвэрийн банк байгуулагджээ.
- Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг Монгол Улсын Төв Банк гэнэ.
- Монгол Улсын Төв Банкыг Монголбанк гэж нэрлэнэ.
- Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.
- Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ.



## 2.МОНГОЛЫН ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ

МОНГОЛБАНК-НЫ ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ӨӨРИЙН ЗОРИЛТЫГ БИЕЛҮҮЛЭХИЙН ТУЛД ДАРААХЬ ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛНЭ:

1. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах;
2. Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
3. Засгийн газарын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх;
4. Банкны үйл ажиллагаанд хяналт тавих;
5. Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах;
6. Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах.



# МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

## МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



# МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- **Захирлуудын зөвлөлийн гишүүд:**

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн дэргэд Монголбанкны Захирлуудын зөвлөл ажиллана.
2. Зөвлөл нь Монголбанкны Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар зөвлөх эрхтэй.
3. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.

- **Хяналтын зөвлөл:**

Хяналтын зөвлөл нь Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагаа, хөндлөнгийн аудитын санал, зөвлөмжийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын багц болон Монголбанкнаас санхүүгийн тайлангаа Улсын Их Хурал, олон нийтэд тайлагнаж, мэдээлж байгаа байдал, Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих эрх бүхий орон тооны бус байгууллага байна.



# МОНГОЛ УЛСЫН ГҮЙЛГЭЭНД БАЙГАА МӨНГӨН ТЭМДЭГТҮҮД

1. Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн албан ёсны нэгж нь төгрөг мөн. Нэг төгрөг зуун мөнгөтэй тэнцэнэ.
2. Монгол Улсын мөнгөн тэмдэгт нь цаасан дэвсгэрт болон зоосон хэлбэртэй байна. Монгол Улсын мөнгөн тэмдэгтийн хэв загварыг Улсын Их Хурал батална.

Монголбанк нь хуурамч мөнгөн тэмдэгт илрүүлэх, хуучирч муудсан эсвэл хуурамч мөнгөн тэмдэгтийг устгах ажлыг зохион байгуулдаг.



# ТӨВ БАНК БОЛОН АРИДЖААНЫ БАНКНЫ ЯЛГАА

Арилжааны банк	Монголбанк
<ul style="list-style-type: none"><li>✓ Ашгийн төлөө</li><li>✓ Мөнгөнтэмдэгт хэвлэж гүйлгээнд гаргах эрхгүй, мөнгөний бодлого боловсруулахгүй.</li><li>✓ Иргэд, аж ахуйн нэгжээс харилцах, хадгаламж татан төвлөрүүлдэг.</li><li>✓ Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад богино, дунд хугацааны зээл олгодог.</li><li>✓ Банк хоорондын төлбөр тооцоог зохицуулах эрхгүй.</li><li>✓ Үйл ажиллагаагаа хувь (хувьцаа) эзэмшигчдийн өмнө тайлагнана.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>✓ Ашгийн бус</li><li>✓ Төрөөс үүсгэн байгуулсан</li><li>✓ Мөнгөнтэмдэгт гүйлгээнд гаргадаг, мөнгөний бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.</li><li>✓ Харилцах дансны эзэмшигчид нь банкууд, Төрийн сангийн нэгдсэн дансын эзэмшигч нь Засгийн газар байдаг.</li><li>✓ Шаардлагатай тохиолдолд Монголбанкнаас арилжааны банкууд болон Засгийн газарт зээл олгодог.</li><li>✓ Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулна.</li><li>✓ Үйл ажиллагаагаа УИХ-ын өмнө тайлагнадаг.</li></ul>



# ТӨВ БАНК МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ХЭРХЭН УДИРДАХ ВЭ?

Төв банк нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах 3 арга хэрэгслийг ашигладаг:

- 1. Богино хугацаат хүүг өөрчлөх:** Хүү буурснаар мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж, эдийн засгийн өсөлтийг идэвхждэг. Харин хүү өсөхөд эсрэгээрээ мөнгөний нийлүүлэлт хумигдаж, эдийн засгийн идэвхжил хазаарлагддаг байна.
- 2. Заавал байлгах нөөцийн хувь хэмжээг өөрчлөх:** Арилжааны банкууд бусдаас татан төвлөрүүлж хадгалж буй мөнгөнийхөө нэг хэсгийг төв банкинд байршуулах ёстой байдаг. Заавал байлгах нөөцийн хувь хэмжээ буурснаар арилжааны банкуудын зээл олголт нэмэгдэж, мөнгөний нийлүүлэлтт өсөх боломжтой юм.
- 3. Нээлттэй захын үйл ажиллагаа явуулах:** Мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх буюу бууруулахын тулд Төв банк нээлттэй захад үнэт цаас худалдан авах эсвэл худалдах үйл ажиллагааг хийдэг.

# ТӨВ БАНК МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙГ ХЭРХЭН УДИРДАХ ВЭ?

- ✓ **Хасах хүүгийн бодлого:** Уламжлалт бус мөнгөний бодлогын нэг арга хэрэгсэл нь хасах хүүгийн бодлого юм. Бодлогын хүү хасах болсноор арилжааны банкууд Төв банкинд мөнгө хадгалуулсныхаа төлөө хүү авах бус хүү төлөх ёстой болно гэсэн үг юм. Ингэснээр арилжааны банкууд мөнгөө төв банкинд хадгалуулах бус харин зээл хэлбэрээр эдийн засагт гаргаж, эдийн засгийн идэвхжлийг дэмжих, цаашлаад инфляцийг өдөөж, зорилтот түвшинд хүргэх зорилготой. ЕВРОП, ШВЕД, ШВЕЙЦАРИ, ДАНИ, ЯПОНЫ төв банкууд.
- ✓ **Quantitative Easing (QE):** Төв банк QE хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ банкнуудын баланс дээрх засгийн газрын бонд зэрэг үнэт цаасыг худалдан авдаг бөгөөд энэ нь нөөц мөнгийг өсгөж, тухайн бондын өгөөжийг бууруулдаг байна. Дэлхийн санхүүгийн хямралаас хойш АНУ, Их Британи, Европын төв банкууд уг бодлогыг хэрэгжүүлж эхэлжээ.
- ✓ **Хүү бага үед төв банкинд тулгарч буй сорилтууд:** Бондын өгөөж буурч, хөрөнгө оруулагчид үл хөдлөх хөрөнгө, хувьцаанд хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж эхэлснээр хувьцааны үнийг өсгөж, хөрөнгийн захад үнийн хөөсрөл бий болгов. Хэрэв энэ хөөс хагарвал хөрөнгийн зах уналтанд орж, санхүүгийн зах зээл ганхах, цаашлаад эдийн засгийн хямралд хүргэх эрсдэлтэй юм.



**Баярлалаа**